

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/010/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a> Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>  Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a>  Аудитор: Э.Энхбүрэн Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:enkhburene@audit.gov.mn">enkhburene@audit.gov.mn</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ .....	4-6
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 7-10	
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	10-18
3.4.1 Мөнгөн хөрөнгө .....	12
3.4.2 Авлага .....	12-13
3.4.3 Бараа материал .....	13
3.4.4 Үндсэн хөрөнгө .....	13-14
3.4.5 Өр төлбөр .....	14
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо .....	14-15
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	18
4.1 Ерөнхий зүйл .....	18
4.2 Материаллаг байдал .....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	19
4.5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	20
4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	20
4.6.1 Завсрын аудитын талаар .....	20
4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	20
4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	20-21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	201
5.1 Төлбөрийн акт .....	21
5.2 Албан шаардлага .....	22-23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	24

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТБОНӨБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



ЖАВХЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Ж.ОТГОНДАЛАЙ ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № СЭА-2025/010/НА-СТА-ТТЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Жавхланта сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Жавхланта сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон **14,578.1** мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 22 дугаар зүйлийн 22.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.4.3, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т заасантай болон Сангийн сайдын 2021 оны 61, 190 дүгээр тушаалуудын

холбогдох заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Сумын ИТХ, ЗДТГ нь орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчдад олгосон мөнгөн урамшууллаас хувь хүний орлогын албан татвар **4,001.9** мянган төгрөгийг суутгаагүй,
- ЗДТГ нь тайлант оны 1 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухайн үеийн үндсэн цалингаас бус 4 дүгээр сард нэмэгдсэн цалингаас тооцож, 3 албан хаагчид **291.0** мянган төгрөгийг илүү олгосон,
- ЗДТГ нь 2023 оны **450.0** мянган төгрөгийн өмнөх оны тайлагнагдаагүй өр төлбөрийг тайлант оны батлагдсан төсвөөс барагдуулж, зардлаар тайлагнасан, **450.0** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, **492.2** мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага үүсгэсэн,
- Малын тоо толгойн албан татварын давсан орлогыг зарцуулах тухай сумын ИТХ-ын тогтоол шийдвэр гараагүй байхад буюу зарцуулах эрх үүсээгүй байхад **20,977.2** мянган төгрөгийг зарцуулсан,
- ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс Ерөө сумын 100 жилийн ойд **3,000.0** мянган төгрөгийн хандив өгч, **863.4** мянган төгрөгийн тэмцээн уралдааныг санхүүжүүлэн төсвийг зориулалт бусаар зарцуулсан,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин **3,000.0** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэсэн байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд 482,274.1 мянган төгрөгийн татварын орлого, 27,368.0 мянган төгрөгийн татварын бус орлого зэрэг нийт 509,642.1 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **589,940.9** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 15.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс тус сумын суурь орлогыг хянаж, батлахдаа малын хөлийн татварын 105,000.0 мянган төгрөгийг суурь орлогод нэмж баталснаас шалтгаалан уг орлогын эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд бус орон нутгийн төсвийн суурь зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Жавхлант сумын Засаг дарга нь тайлант онд 16 зорилт, 125 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 97.1 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>340,082.7</b>	<b>357,910.50</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	207,245.8	124,088.00
33	АВЛАГА	102,202.2	181,111.80
35	БАРАА МАТЕРИАЛ	30,634.7	44,800.60
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	7,910.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,665,650.6</b>	<b>1,914,401.70</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,665,650.6	1,914,401.70
39200	Биет хөрөнгө	1,661,664.7	1,910,415.80
39300	Биет бус хөрөнгө	3,985.9	3,985.90
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,005,733.3</b>	<b>2,272,312.20</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>14,682.3</b>	<b>0.0</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,682.3	685.2
41300	Өглөг	14,682.3	685.2
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,991,051.0</b>	<b>2,272,312.20</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,991,051.0	2,272,312.20
51100	Засгийн газрын оруулсан капитал	339,508.6	339,508.60
51200	Хуримтлагдсан үр дүн	1,410,245.6	1,691,506.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	241,296.8	241,296.80
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,005,733.3</b>	<b>2,272,312.20</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,769,325.7</b>	<b>2,512,458.50</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	380,455.9	553,885.70
110	Орлогын албан татвар	194,440.7	357,539.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	216,518.5	386,251.30
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-22,077.8	-28,711.70
113	Хөрөнгийн албан татвар	128,259.6	140,405.80
118	Бусад татвар, төлбөр, хураамж	57,755.5	55,940.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	308,641.4	527,926.10
120	Нийтлэг татварын бус орлого	308,641.4	527,926.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,080,228.4	1,430,646.60
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,457,806.6</b>	<b>1,843,108.50</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,457,806.6	1,843,108.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,410,534.4	1,789,536.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	461,328.0	745,458.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,747.3	88,497.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,352.1	476,860.70
2104	Хангамж, бараа материалын зардал	42,221.2	58,570.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,319.2	36,090.80
2107	Томилолт, зочны зардал	4,118.4	8,414.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	379,885.8	10,650.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	378,562.3	364,994.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,272.2	53,571.90
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>311,519.1</b>	<b>669,350.00</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>281,051.6</b>	<b>388,088.80</b>

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	30,467.5	281,261.20
----	---	----------	------------

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,960,583.50	1,960,583.50
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,960,583.50	1,960,583.50
9	Тайлант үеийн үр дүн	30,467.50	30,467.50
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,991,051.00	1,991,051.00
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,991,051.00	1,991,051.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,991,051.00	1,991,051.00
19	Тайлант үеийн үр дүн	281,261.20	281,261.20
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,272,312.20	2,272,312.20

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,543,754.60	2,042,205.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	380,455.90	553,885.70
110	Орлогын албан татвар	194,440.70	357,539.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	216,518.50	386,251.30
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(22,077.80)	(28,711.70)
113	Хөрөнгийн албан татвар	128,259.60	140,405.80
118	Бусад татвар, төлбөр, хураамж	57,755.50	55,940.40
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,909.70	5,090.70
1181	Газрын төлбөр	40,606.90	36,971.30
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	13,238.90	13,878.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	83,070.30	57,672.80
120	Нийтлэг татварын бус орлого	83,070.30	57,672.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,080,228.40	1,430,646.60
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,204,038.50	1,631,043.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,204,038.50	1,631,043.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,156,766.30	1,576,971.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	460,236.50	744,976.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,523.40	89,626.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,576.60	490,525.60
2104	Хангамж, бараа материалын зардал	37,994.30	53,925.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,089.20	35,087.60
2107	Томилолт, зочны зардал	4,118.40	8,414.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	381,639.60	11,311.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	141,588.30	143,104.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,272.20	54,071.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	339,716.10	411,162.20
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	298,183.80	394,320.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	298,183.80	394,320.00
2200	Дотоод эх үүсвэрээр	298,183.80	394,320.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-298,183.80	-394,320.00

VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-35,000.00	-100,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	35,000.00	100,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	6,532.30	-83,157.70
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	200,713.50	207,245.80
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	207,245.80	124,088.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт /хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,236,703.30	2,112,933.97	123,769.33	5.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,652,195.50	1,624,845.13	27,350.37	1.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,597,010.40	1,570,773.22	26,237.18	1.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	752,278.50	744,976.30	7,302.20	0.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,475.10	89,626.76	9,848.34	9.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	492,263.10	486,753.61	5,509.49	1.12
2104	Хангамж, бараа материалын зардал	55,615.00	53,383.44	2,231.56	4.01
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,443.20	38,438.73	4.47	0.01
2107	Томилолт, зочны зардал	32,212.00	32,207.63	4.38	3.14
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,756.00	10,744.28	1,011.72	8.61
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	138,492.90	138,436.10	56.80	0.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,185.10	54,071.91	1,113.19	2.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,185.10	54,071.91	1,113.19	2.02
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	484,507.80	388,088.85	96,418.95	19.90
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,000.00	100,000.00	0.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,236,703.30	2,005,032.19	231,671.11	10.36
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	0.00	0.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,017,637.10	1,982,459.63	35,177.47	1.74
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	219,066.20	22,572.57	196,493.64	89.70
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	201,616.26	(201,616.26)	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	93,714.48	(93,714.48)	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	52.0	52.0	0.0	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.0	2.0	0.0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25.0	25.0	0.0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.0	25.0	0.0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
------	---------------------	-----------------------

<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>13,114.15</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>13,114.15</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,428.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,772.00
2104	Хангамж, бараа материалын зардал	541.94
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,880.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	567.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,667.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	685.21
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>13,114.15</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,114.15
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,276.93
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,837.22
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.0</b>

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жавхлант сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хүнээ хөгжүүлж, өрх бүр үйлдвэрлэгч, ажил орлоготой байх нөхцөлийг бүрдүүлж, ногоон хөгжлийг эрхэмлэсэн сум болох.” гэж тодорхойлсон байна. Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн ажил үйлчилгээг нээлттэй, ил тод шуурхай хүргэх
- Ажлын хариуцлага, сахилга, ёс зүйг дээшлүүлэх
- Өрхийн амьжиргааг дээшлүүлэх, өрх бүр үйлдвэрлэгч байх
- Мэдээ, мэдээллийн ил тод байдлыг ханган иргэдэд цаг алдалгүй хүргэх, зорилгоор мэдээллийн орчин нөхцөлийг сайжруулах

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг баталсан,

- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт нь оновчтой, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

2024 онд тус ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй боловч ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналт, шалгалтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жавхлант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Жавхлант сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”- ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Жавхлант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 266,578.9 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	207,245.80	124,088.00	(83,157.80)
Авлага	102,202.20	181,111.80	78,909.60
Бараа материал	30,634.70	44,800.60	14,165.90
Нөөцийн бараа	0.00	7,910.10	7,910.10
Үндсэн хөрөнгө	1,665,650.60	1,914,401.70	248,751.10
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,005,733.30</b>	<b>2,272,312.20</b>	<b>266,578.90</b>
Өр төлбөр	14,682.30	0.00	(14,682.30)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,991,051.00	2,272,312.20	281,261.20
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,005,733.30</b>	<b>2,272,312.20</b>	<b>266,578.90</b>

Эх сурвалж: Жавхлант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсныг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 124,088.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 83,157.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	207,245.8	124,088.00	(83,157.80)
Төгрөг	207,245.8	124,088.00	(83,157.80)
Төрийн сангийн харилцах	207,245.8	124,088.00	(83,157.80)
<b>Дүн</b>	<b>207,245.8</b>	<b>124,088.00</b>	<b>(83,157.80)</b>

Эх сурвалж: Жавхлант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 30,373.50 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 88,080.5 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн үлдэгдэл 5,634.0 мянган төгрөг тус тус байршиж байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 181,111.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 78,909.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон авлага	0.00	492.20	492.20
Зээлийн хүүгийн авлага	4,750.20	4,693.6	(56.6)
Байгууллагаас авах авлага	0.00	0.00	0.00
Хувь хүмүүсээс авах авлага	2,293.40	2,293.40	0.00
Хувь хүмүүст олгосон зээл	95,158.60	173,632.6	78,474.0

<b>Дүн</b>	<b>102,202.20</b>	<b>181,111.80</b>	<b>78,909.60</b>
------------	-------------------	-------------------	------------------

Эх сурвалж: Жавхлант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны авлагын эхний үлдэгдэл 102,202.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 181,111.8 мянган төгрөг болж, 78,909.6 мянган төгрөгөөр өссөн нь хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгосонтой холбоотой байна.

Төрийн сангийн 2,293.4 мянган төгрөгийн авлага нь аймгаас иргэдэд олгосон итгэлийн зээлийн авлага юм.

Тайлант оны нийт авлагын үлдэгдлийн 98.5 хувь буюу 178,326.2 мянган төгрөгийг Хоршоог хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлагын үлдэгдэл эзэлж байна. Үүнээс 100,000.0 мянган төгрөг буюу 56.0 хувь нь 2024 онд олгосон зээлийн авлага байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 44,800.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 14,165.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>6,594.30</b>	<b>20,150.21</b>	<b>13,555.91</b>
Тусгай зориулалттай материал	6,594.30	20,150.21	13,555.91
Эм боох материал	0.00	0.0	0.0
<b>Хангамжийн материал</b>	<b>24,040.40</b>	<b>24,650.39</b>	<b>609.99</b>
Бичиг хэргийн материал	2,323.70	2,178.67	(145.00)
Аж ахуйн материал	13,959.30	16,590.19	2,630.85
Сэлбэг хэрэгсэл	4,114.00	2,500.00	(1,614.00)
Түлш, шатах тослох материал	0.00	468.53	468.53
Хүнсний материал	0.00	0.0	0.0
Бусад хангамжийн материал	3,643.40	2,913.01	(730.39)
<b>Мал амьтад</b>	<b>0.00</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>Дүн</b>	<b>30,634.70</b>	<b>44,800.60</b>	<b>14,165.90</b>

Эх сурвалж: Жавхлант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 14,165.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 523,860.00 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон 121,605.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 388,088.8 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэнтэй холбоотой байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,914,401.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 248,751.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>1,661,664.70</b>	<b>1,910,415.80</b>	<b>248,751.1</b>
Барилга, байгууламж, орон сууц	493,806.60	487,701.70	(6,104.9)
Авто-тээврийн хэрэгсэл	102,715.10	161,943.40	59,228.3

Машин тоног төхөөрөмж(компьютер)	46,046.20	30,994.20	(15,052.00)
Тавилга, аж ахуйн эд хогшил	18,466.70	15,342.70	(3,124.00)
Дуусаагүй барилга байгууламж	0.00	0.0	0.00
Номын фонд	0.00	0.0	0.00
Бусад үндсэн хөрөнгө	1,000,630.10	1,214,433.80	213,803.70
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>3,985.90</b>	<b>3,985.9</b>	<b>0.00</b>
Программ хангамж	996.90	996.9	0.00
Бусад биет бус хөрөнгө	2,989.00	2,989.0	0.00
<b>Дүн</b>	<b>1,665,650.60</b>	<b>1,914,401.70</b>	<b>248,751.1</b>

Эх сурвалж: Жавхлант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 248,751.1 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил, гүйлгээнээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Барилга байгууламж 20,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь сумын ОНХС-ийн хөрөнгөөр төрийн албан хаагчийн байр худалдан авсан.
- Авто тээврийн хэрэгсэл 89,786.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Засгийн газрын хэрэг эрхлэх газраас Пикап жип автомашин үнэ төлбөргүй олгосон.
- Тоног, төхөөрөмж 6,231.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Засаг даргын Тамгын газар төсвийн хөрөнгөөр 4,499.9 мянган төгрөгийн хэвлэгч, хувилагч, мини ирад худалдан авсан болон ИТХ нь 1,731.2 мянган төгрөгийн зөөврийн компьютер худалдан авсан.
- Бусад үндсэн хөрөнгө 442,923.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 97,645.1 мянган төгрөгийн тоглоомын талбайн тохижилтын ажил хийгдэж, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 345,278.8 мянган төгрөгийн гэрэлтүүлэг засвар, камержуулалт зэрэг төсөл, арга хэмжээг бүртгэснээс,
- Тайлант онд 58,850.1 мянган төгрөгийн үйлчилгээний барилга, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийг сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 07 дугаар тогтоолоор акталсан байна.

### 3.4.5 Өр төлбөр

Тайлант онд өмнөх оны дансны үлдэгдэл 14,682.3 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	155.0	0.0	(155.0)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	13,775.5	0.0	(13,775.5)
Байгууллагад төлөх өглөг	751.8	0.0	(751.8)
<b>Дүн</b>	<b>14,682.3</b>	<b>0.0</b>	<b>(14,682.3)</b>

Эх сурвалж: Жавхлант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,272,312.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 281,261.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	339,508.65	339,508.65	0.0
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,410,245.60</b>	<b>1,691,506.8</b>	<b>281,261.2</b>
Өмнөх үеийн үр дүн	1,379,778.1	1,410,245.60	30,467.5
Тайлант үеийн үр дүн	30,467.5	281,261.2	250,793.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	241,296.8	241,296.8	0.00
<b>Дүн</b>	<b>1,991,051.0</b>	<b>2,272,312.2</b>	<b>281,261.2</b>

Эх сурвалж: Жавхлант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл урьд оноос 281,261.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Жавхлант сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн “2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 35 дугаар тогтоолоор 482,274.1 мянган төгрөгийн татварын орлого, 27,368.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **589,940.9** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 15.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татварын орлого</b>	<b>482,274.1</b>	<b>554,840.7</b>	<b>72,566.6</b>	<b>115.1</b>
Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	263,671.1	285,136.3	21,465.2	108.1
Үйл ажиллагааны орлого	70,100.0	92,394.0	22,294.0	131.8
Хөрөнгийн орлого	12,837.0	7,319.40	(2,919.9)	71.5
Хөрөнгө борлуулсны орлого	1,200.0	1,401.6	201.6	116.8
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(28,711.7)	(28,711.7)	-	100
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	3,000.0	3,404.6	404.6	113.5
Галт зэвсгийн албан татвар	600.00	690.00	90.0	115.0
Малын тоо толгойн албан татвар	105,000.0	136,311.3	31,311.3	129.8
Улсын тэмдэгтийн хураамж	2,500.0	2,841.7	341.7	113.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,000.0	2,249.00	249.0	112.5
Газрын төлбөр	21,277.7	21,727.8	450.1	102.1
Газрын дуудлага худалдаа	15,000.0	15,243.5	243.5	101.6
Байгалийн ургамал ашигласны төлбөр	13,800.0	13,878.40	78.4	100.6
<b>Татварын бус орлого</b>	<b>27,368.0</b>	<b>35,100.2</b>	<b>7,732.2</b>	<b>128.3</b>
Хүү, торгуулийн орлого	26,900.0	33,233.6	6,333.6	123.5
Бусад орлого	468.0	1,866.6	1,398.6	398.8
<b>Нийт дүн</b>	<b>509,642.1</b>	<b>589,940.9</b>	<b>80,298.8</b>	<b>115.8</b>

Эх сурвалж: Жавхлант сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- *Малын тоо толгойн албан татварын орлого 31,311.3 мянган төгрөгөөр давж биелсэн нь орлогыг дутуу төлөвлөснөөс,*
- *Үйл ажиллагааны орлого 22,294.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь ноос ноолуурын урамшууллын орлогоос суутгасан татвараас,*
- *Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 21,465.2 мянган төгрөгөөр давж биелсэн нь 2024 оны 4 дүгээр сараас төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнээс тус тус шалтгаалсан байна.*

Тасарсан орлого:

- *Хөрөнгийн орлого 2,919.9 мянган төгрөгөөр тасарсан нь банкин дахь иргэдийн хадгаламж буурснаас шалтгаалсан байна.*

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Сумын ИТХ-ын 2023 оны 20 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 518,905.0 мянган төгрөгөөр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 1,096,639.1 мянган төгрөгөөр, төсөвт газрын өөрийн орлогыг 500.0 мянган төгрөгөөр, ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 276,903.8 мянган төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 213,622.8 мянган төгрөгөөр, ХХС-ын орлогыг 101,550.0 мянган төгрөгөөр зэрэг нийт орлогыг **2,208,120.7** мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 35 дугаар тогтоолоор дараах өөрчлөлтийг оруулан төсвийн орлого, зарлагыг 28,582.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, тус бүр **2,236,703.3** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

Санхүүжүүлэх эх үүсвэрийн өөрчлөлт:

- *Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 35,000.0 мянган төгрөгөөр,*
- *Үйл ажиллагааны орлогыг 38,608.1 мянган төгрөгөөр,*
- *Байгалийн ургамал ашигласны төлбөрийг 1,800.0 мянган төгрөгөөр,*
- *ХХАОТ-ын буцаалтыг 1,223.3 төгрөгөөр*
- *Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 400.0 мянган төгрөгөөр*
- *Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 43,464.3 мянган төгрөгөөр*
- *Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг 11,941.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж,*
- *Хөрөнгийн орлогыг 5,000.0 мянган төгрөгөөр*
- *Хөрөнгө борлуулсны орлогыг 5,329.8 мянган төгрөгөөр*
- *Бууны татвар 600.0 мянган төгрөгөөр*
- *Малд ногдуулах албан татварыг 43,039.6 мянган төгрөгөөр*
- *Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 2,800.0 мянган төгрөгөөр*
- *Улсын тэмдэгтийн хураамж 500.0 мянган төгрөгөөр*
- *Газрын төлбөр 2,905.3 мянган төгрөгөөр*
- *Ойн нөөц ашигласны төлбөр 400.0 мянган төгрөгөөр*
- *Ус рашаан ашигласны төлбөр 10,241.0 мянган төгрөгөөр*

- Бусад орлогыг 9,532.0 мянган төгрөгөөр
- Торгуулийн орлогыг 3,100.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан,

#### Төсвийн зарлагын өөрчлөлт:

- ЗДТГ-ын урсгал зардлыг 66,150.0 мянган төгрөгөөр,
- ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардлыг 15,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж
- ИТХ-ын урсгал зардлыг 9,750.0 мянган төгрөгөөр,
- ОНХС-гийн зардлыг 42,817.4 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,140,103.4 мянган төгрөгийг аймгийн төсвөөс, 288,845.4 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 195,662.4 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 101,550.0 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөлтөөс, 509,642.1 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 900.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос зэрэг нийт **2,236,703.3** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,140,103.3 мянган төгрөгийг аймгийн төсвийн санхүүгийн дэмжлэгээс, 278,735.8 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 195,662.4 мянган төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 101,550.0 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөлтөөс, 588,986.1 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 955.0 мянган төгрөгийг өөрийн орлогоос зэрэг нийт **2,305,992.6** мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,112,933.9** мянган төгрөг буюу **94.5** хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшил болон НДШ-ийн зардлыг 17,150.5 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 5,509.5 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 96,418.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 16 төсөл, арга хэмжээнд 484,507.8 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 396,419.3 мянган төгрөгийн санхүүжилт олгон, 88,088.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь сумын гэрэлтүүлэг засварын төсөл арга хэмжээ 8,632.7 мянган төгрөгөөр, зураг төсөв хийгдэх зардал 124.2 мянган төгрөгөөр хэмнэгдсэн болон хайрган хучилтай зам засварлах 59,581.4 мянган төгрөгийн төсөл арга хэмжээ хэрэгжээгүй зэргээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДНХ-өөс 168.0 мянган төгрөг, сумдын ЗДНХ-өөс 4,500.0 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс 1,108.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7,337.2 мянган төгрөг зэрэг нийт 13,114.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал зардалд 12,428.9 мянган төгрөгийг зарцуулан, 685.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сумын ОНХС-ийн төсвөөс 443,507.8 мянган төгрөгийн 13 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, баталсан байна.

Гүйцэтгэлээр харьцуулалтын аргаар гүйцэтгэх 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

*Хүснэгт 9. Худалдан авах ажиллагаа*

*/мянган төгрөгөөр/*

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Нийт төсөл, арга хэмжээ		Үүнээс					
			Шууд худалдан авалт		Харьцуулалтын арга		Нээлттэй тендер шалгаруулалт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ОНХС	3	281,710.1			3	281,710.1		

Эх сурвалж: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жавхлант сумын ТТЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Энхбүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Жавхлант сумын ТТЗ нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/72 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 1,457,806.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **14,578.1** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Жавхлант сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлсэн,*
- *Тээврийн хэрэгслүүдийг ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар хангасан,*
- *Зайлшгүй шаардлагатай зардлаас бусад зардлыг танасан зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр зардлуудыг хэмнэж, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.*

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 33 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн заалтыг зөрчин сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулган хадгалан үлдэх зорилгоор **3,000.0** мянган төгрөгийг “Монголын баялаг өв соёл” ХХК-тай гэрээ байгуулан шилжүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4: “...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 10. Шилэн данс

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	151	151	-	
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	151	151	-	
3	Засаг даргын Тамгын газар	151	151	-	
	<b>Нийт дүн</b>	<b>453</b>	<b>453</b>	-	

Эх сурвалж: [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)

ТТЗ-ийн түвшинд нийт мэдээлбэл зохих 453 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж үзлээ.

#### 4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.6.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 10 дугаар сарын 26-ны 122 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### 4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 91.7 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 11. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,201.0	1	1,201.0	100.0
Албан шаардлага	6	38,788.6	5	30,820.6	83.3
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>39,989.6</b>	<b>6</b>	<b>108,576.5</b>	<b>91.7</b>

Эх сурвалж: Жавхлант сумын ТТЗ-ын 2023 оны аудитын тайлан

#### 4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах

ажиллагаатай холбоотой асуудлуудыг уг аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа. Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн” болон “ОНХС-ийн 2024 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай.

**2.Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр** хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс тус сумын суурь орлогыг хянаж, батлахдаа малын хөлийн татварын 105,000.0 мянган төгрөгийг суурь орлогод нэмж баталснаас шалтгаалан уг орлогын эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд бус орон нутгийн төсвийн суурь зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь “малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт **30,525.7** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс **4,292.9** мянган төгрөгийн төлбөрийн акт, **26,232.8** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэв.

### **5.1 Төлбөрийн акт**

1. Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг үндэслэн орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны 5 албан хаагчид олгосон **40,019.0** мянган төгрөгийн мөнгөн урамшууллаас хувь хүний орлогын албан татварын **4,001.9** мянган төгрөгийг суутгаагүй байна. Үүнд:

- ИТХ нь 1 албан хаагчийн 946.6 мянган төгрөг,
- ЗДТГ нь 4 албан хаагчийн 3,055.3 мянган төгрөг,

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 6.3.1: “... урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 22 дугаар зүйлийн 22.1 дэх “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө” 22.1.1:

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*“хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ХХОАТ-ыг нөхөн суутгаж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

**2. ЗДТГ нь** Тайлант оны 1 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухайн үеийн үндсэн цалингаас бус 4 дүгээр сард нэмэгдсэн цалингаас тооцож, 3 албан хаагчид **291.0** мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь *“Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:”* 20.2.5 дахь *“... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## **5.2 Албан шаардлага**

**1. ЗДТГ:** 2023 оны санхүүгийн программын **450.0** мянган төгрөгийн өр төлбөрийг өмнөх оны санхүүгийн тайланд тусгалгүйгээр тайлант оны батлагдсан төсвөөс барагдуулж, зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх *“Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх *“Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:”,* 14.4.3: *“бүх өр төлбөр”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

**2. ЗДТГ:** Бараа үйлчилгээний бусад зардлаас мэдээлэл технологийн зардалд **450.0** мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно”* гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан *“Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”*-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

**3.ЗДТГ:** Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс **492.2** мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог **хянах**...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**4.** Малын тоо толгойн албан татварын давсан орлогыг зарцуулах тухай сумын ИТХ-ын тогтоол шийдвэр гараагүй байхад буюу зарцуулах эрх үүсээгүй байхад **20,977.2** мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “**Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах**” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ИТХ-ын тогтоолоор батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах, зайлшгүй тохиолдолд ИТХ-д өргөн мэдүүлж, шийдвэрлүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

**5.** ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс Ерөө сумын 100 жилийн ойд 3,000.0 мянган төгрөгийн хандив өгч, 863.4 мянган төгрөгийн тэмцээн уралдааныг санхүүжүүлэн төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “**Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах**”, гэсэн заалт болон Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1-2.1.6 дугаар заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

#### **1.Цалингийн зардалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: ЗДТГ нь зарим албан хаагчдад цалинтай чөлөөг дотоод журамд зааснаас илүү хоногоор тооцож олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай 100 дугаар зүйлийн 100.2 дахь “**Хувийн чөлөө олгох журам, чөлөөний хугацаа, хувийн чөлөөтэй байх хугацаанд олговор олгох эсэхийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна**”, Хөдөлмөрийн дотоод журмын 5.2 дахь “**...Цалинтай чөлөөний хугацаа жилдээ ажлын 5 өдрөөс илүүгүй байна**” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажиллах, шаардлагатай тохиолдолд хамт олны хурлаар хэлэлцэн шинэчлэх .

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	2	24,840.6			2	24,840.6						
ИТХ	1	946.6	1	946.6								
ЗДТГ	6	4,738.5	2	3,346.3	3	1,392.2	1					
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>30,525.7</b>	<b>3</b>	<b>4,292.9</b>	<b>5</b>	<b>26,232.8</b>	<b>1</b>					

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой</b>								
ЗДТГ нь түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулгасан								
	1	3,000.0				1	3,000.0	
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>3,000.0</b>				<b>1</b>	<b>3,000.0</b>	
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>3,000.0</b>				<b>1</b>	<b>3,000.0</b>	